

Гүйцэтгэлийн үнэлгээний бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч, Цагаан-Өвгөн Бумангэрэл

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Гүйцэтгэлийн зорилт №1.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах							
1	Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журмыг батлуулна.	Засгийн газрын тогтоол	Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/500 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэл”	Журмын дагуу санхүүжилтийг олгосон байна.	Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийг үндэслэн "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, багшийн ажлын гүйцэтгэл, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"-ыг Санхүү, хөрөнгө оруулалтын газартай хамтран ажиллаж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр холбогдох баримт бичгийн хамт хавсралтаар хүргүүлж, 20 яамнаас санал авч нэгтгэн, Засгийн газрын	1-р сар, 6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хуралдаанаар хэлэлцүүлэв. Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"-ыг батлуулав. Хавсралт: 24 файл		
1.2. Боловсрол, шинжлэх ухааны хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах							
2	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	Сайдын тушаал, журам	БШУ-ны сайдын 2022 оны А/430 дугаар тушаал	Журмыг шинэчлэн боловсруулах ажлыг сургууль, цэцэрлэг дээр туршин шаардлагатай арга хэмжээ авсан байна.	1. Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2-т заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Журам батлах тухай" 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/115 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар "Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам", хоёрдугаар хавсралтаар "Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам"-ыг тус тус баталсан. Энэхүү тушаалыг эрх зүйн	3-р сар, 6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх албан бичгийг хүргүүлсэн боловч уг тушаалыг захиргааны хэм хэмжээний актын шинжийг агуулаагүй, удирдлага зохион байгуулалтын шинжтэй захиргааны акт байх тул түүгээрээ мөрдөх талаар Хууль зүй дотоод хэргийн сайдын 2024.04.04-ний өдрийн 1/1592 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн болно. 2. Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг болон багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх турших ажлыг зохион байгуулах зардлыг батлах Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/114 дүгээр тушаалаар батлан Нийслэлд 12 сарын эхний 7 хоногт, ,3 дахь 7 хоногт орон нутагт туршилтын ажлыг хийж, нэгдсэн үр дүнг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны дотор танилцуулахаар бэлтгэж байна. Хавсралт: 3 файл	
--	--	--	--	--	--	--

3	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаандаа өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журмыг боловсруулж, батлуулна.	Сайдын тушаал, журам	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2019 оны А/803 дугаар тушаал	Журмыг батлуулсан байна.	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн тухай хуулийн 18.7.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагаандаа өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагаа, суралцагчийн хөгжил, сурлагын амжилтын чанар, үр дүнг тасралтгүй сайжруулна. 26.6.Энэ хуулийн 18.7-д заасан үнэлгээ хийх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэсний дагуу ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨӨРИЙН БОЛОН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ"-ыг гэрээт ажилтан Ч.Ганцэцэгтэй хамтран /2 сарын 06 -4 сарын 06/ шинэчлэн боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 15/1397 дугаар албан бичгээр журмын төсөлд Орон нутгийн БШУГ-уудаас санал авч нэгтгэн , Сургуулийн өмнөх боловсролын хэлтэс,	7-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
---	---	----------------------	---	--------------------------	--	-------------------	---

					Ерөнхий боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын саналыг тусган журмын төслийг батлуулахаар Эйбл системд оруулав.Сайд Гүйцэтгэлийн үнэлгээний журамд өөрийн үнэлгээг оруулбал үүнийг тусдаа хийх шаардлагагүй. Түр байлгаж бай гэсэн ба Гүйцэтгэлийн үнэлгээнд өөрийн үнэлгээний асуудлыг тусган туршилтын ажил явагдаж байгаа ба үр дүн 2025 оны 01 сард гарна. Хавсралт: 3 файл		
4	Боловсролын багц хуулиудыг сурталчлан таниулах	Боловсролын багц хуулиудыг сурталчлан таниулах ажлын удирдамж	-	-	Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.03.22-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар байгуулагдсан ажилын хэсэгт орж Боловсролын багц хуулийг сурталчлан таниулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах ажлыг нийслэлийн Баянзүрх, Багахангай дүүргийн, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймгийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын	6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					сургуулийн удирдах ажилтнуудад зохион байгуулав. Хавсралт: 7 файл		
1.3. Боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл боловсруулах, батлуулах, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төсөл боловсруулах, салбар хоорондын уялдааг бодлогын удирдамжаар хангах, боловсролын чанарын үнэлгээ болон насан туршдаа суралцахуйн тогтолцоог хөгжүүлж бүх түвшний боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах бодлогын чиглэл боловсруулах							
5	“Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулна.	Тогтоолын төсөлд тусгах санал	Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад орсон өөрчлөлт /ЗГ-ын 252-р тогтоол/	Тогтоолын төсөлд тусгах саналыг боловсруулж, холбогдох яаманд хүргүүлсэн байна.	Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Журам батлах тухай” 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын “Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, бусад ажилтанд олгох улирлын ажлын гүйцэтгэл үр дүнгийн мөнгөн урамшуулал” хэсэгт өөрчлөлт оруулах санал боловсруулан Боловсролын сайдын 1/1224 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хүргүүлсэн. Хавсралт: 1 файл	10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

1.5. Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хэрэгжилтийг хангах

6	Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд үндэсний чуулган зохион байгуулна.	Сайдын тушаал, чуулганы зөвлөмж	-	-	“Алсын хараа – 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 1.3, Монгол хэлний тухай хуулийн 13.1.6, Засгийн газрын 2022 оны “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 7 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Монгол хэл, бичгийн асуудал шийдэл 2024” үндэсний чуулганы үйл ажиллагааг Соёлын төв өргөөнд 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 500 орчим хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулав. Уг арга хэмжээг зохион байгуулахад БШУЯ-ны зүгээс 25.3 сая төгрөг зарцуулав. Үндэсний чуулганы зохион байгуулалтыг хангаж хөтөлбөрийг эцэслэн зохион байгуулалтыг хийж, чуулганыг зохион байгууллаа. БШУ-ны сайд Л.Энх-Амгалан "МОНГОЛ ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ҮР ДҮН" сэдвээр илтгэл хэлэлцүүлээ. Чуулганы арга хэмжээг МҮОНТВ-ээр шууд	1-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	--	---------------------------------	---	---	---	---------	--

					нэвтрүүлэн олон түмэнд хүргэсэн болно. Хавсралт: 11 файл		
7	Монгол хэлний академик үгийн сангийн судалгааны ажлын хүрээнд веб сайт, аппликэйшн бүтээх, цахим толь бүтээнэ.	Судалгааны ажил, түүний үр дүн	-	Судалгааны ажлын хүрээнд веб сайт хөгжүүлэх ажлыг туршсан байна. аппликэйшн, цахим толийн эхийг боловсруулсан байна.	Монгол хэлний үгийн санг баяжуулах, үндэсний сан хөмрөг бий болгох зорилгоор "Монгол хэлний академик үгийн сангийн судалгаа"-ны ажлыг хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулах эрхийг БШУСайдын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/88 дугаар тушаалаар нэг зуун сая төгрөгийн эрхийг БСҮХ-д шилжүүлсэн. 2024.11.25-ны байдлаар веб сайт хөгжүүлэлтийн ажил 87.7%, аппликэйшн веб сайтын дараа offline орчинд ажиллах байдлаар ашиглахаар хийж байна. Монгол хэлээр боловсрол эзэмшиж буй (сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд) хүүхдүүдэд зориулсан судлагдахууны буюу академик болон соёлын өв үгийн сангийн жагсаалтыг гаргаж, сургалтын төрөл бүрийн толь бичиг боловсруулан хэрэглээнд оруулахын зэрэгцээгээр гадаадад оршин сууж буй хүүхдүүдэд зориулан, олон	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					хэлний орчинд монгол хэл заах А, В, С түвшний үгийн жагсаалт гаргаж зурагт толь бичиг боловсруулан хэрэглээнд оруулахад ашиглах зургийн сан бүрдүүлэх зорилгоор Зурагт толийн зургийн сан бүрдүүлэх, Монгол хэлээр боловсрол эзэмшиж буй сургуулийн өмнөх, бага анги, гадаадад оршин сууж буй хүүхдүүдэд зориулан, олон хэлний орчинд монгол хэл заах зорилготойгоор бүтээгдэж байна. Дэлгэрэнгүй тайланг хавсаргав. Хавсралт: 2 файл		
8	Монголын сайхан бичигтэн 2024 олон улсын уралдаан зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх	Сайдын тушаал	Монголын сайхан бичигтэн 2023 улсын уралдаан	Монголын сайхан бичигтэн 2024 олон улсын уралдаан зохион байгуулж, шаардагдах зардлыг шийдвэрлэсэн байна.	"Монголын сайхан бичигтэн 2024" Олон улсын уралдааныг МОНЦАМЭ агентлагтай хамтран зохион байгуулахаар "Зардал батлах тухай" Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/111 дугаар тушаалыг батлууллаа. / Уралдааны шагналын санд 22.0 сая төгрөг/ Хавсралт: 2 файл	10-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
9	Дээд боловсролын сургалтын	Засгийн газрын	БШУсайдын 2024 оны А/66 тушаал	Засгийн газрын хуралдаанд	Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09	10-р сар, 11-р сар,	Өөрийн үнэлгээ: 100%

	байгууллагад элсэн суралцагчид элсэлтийн шалгалтын монгол хэлний шалгалтыг 10 дугаар ангиас эхлэн өгөх боломжийг олгож, зохион байгуулалтыг уян хатан болгох	хуралдааны тэмдэглэл, сайдын тушаал		Боловсролын сайд мэдээлэл танилцуулж, сайдын тушаалд өөрчлөлт орсон байна.	дүгээр сарын 18-ны өдрийн 01 дугаартай албан даалгаврын 16.4-т "дээд боловсролын элсэлтийн шалгалтын монгол хэлний шалгалтыг 10 дугаар ангиас эхлэн өгөх боломжийг олгож, зохион байгуулалтыг уян хатан болгох" -ыг Боловсролын сайдад даалгасантай холбогдуулан "Ерөнхий боловсролын сургууль төгссөн, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авч байгаа монгол хэл, бичгийн шалгалтын талаарх" асуудлыг Боловсролын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/213 дугаар тушаалаар "Элсэлтийн шалгалт зохион байгуулах журам"-д (БШУ-ы сайдын 2024 оны "Журам батлах тухай" А/66 дугаар тушаалаар баталсан) нэмэлт өөрчлөлт орууллаа. Хавсралт: 1 файл	12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.1. Чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээ, олон улсын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах							
10	PISA-2025 Олон улсын сурлагын амжилтын судалгааг зохион	Туршилтын судалгаа	PISA-2022 судалгааны үр дүн	Туршилтын судалгааны үр дүнгийн тайланг	БЕХуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу БШУЯ, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн	4-р сар, 5-р сар, 6-р сар, 12-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

	байгуулах бэлтгэл ажлыг хангаж, туршилтын судалгааны ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана.			нэгтгэсэн байна.	байгууллагын хооронд “2025 онд Олон улсын суралцагчийн үнэлгээнд оролцох тухай (PISA)” гэрээг байгуулсан. 2025 оны 03 сарын 05-ны өдрөөс 05 сарын 16-ны өдрийн хооронд зохион байгуулагдах Үндсэн судалгааны бэлтгэл хангах ажлын хүрээнд судалгааны нээлттэй даалгавар, аргачлалыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын түвшинд зохион байгуулахаар төлөвлөсөн. Энэхүү арга хэмжээний нэг хэсэг болох нээлттэй даалгаврыг турших, түгээн дэлгэрүүлэх судалгааг түүврийн аргаар, төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 29 сургууль, мэргэжлийн боловсролын 1 сургалтын байгууллагад суралцаж буй 15 настай 1415 суралцагчийг хамруулан 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 02-ны өдрийн хооронд БҮТ-ийн exam.eec.mn сайтад, цахим хэлбэрээр зохион	сар	даргын үнэлгээ: 60% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
--	---	--	--	------------------	--	-----	--

					байгууллаа. Туршилт судалгааны байгалийн ухааны шалгалтыг 29 сургуулийн 1364 суралцагч өгсөн бөгөөд дундаж гүйцэтгэл 37.0%, үр дүнгээс харахад, судалгаанд хамрагдсан нийт сургуулиудын 14 нь буюу 48.3% нь дундаж гүйцэтгэлээс дээгүүр, 15 нь буюу 51.7% нь дунджаас доогуур гүйцэтгэлтэй гарсан байна.Математикийн шалгалтад 29 сургуулийн 1351 сурагч оролцсон бөгөөд дундаж гүйцэтгэл нь 20.4 хувьтай байна. Туршилт судалгааны унших чадварын шалгалтад 29 сургуулийн 1351 суралцагч өгсөн бөгөөд дундаж гүйцэтгэл 46.6 хувьтай, үр дүнгээс харахад, судалгаанд хамрагдсан нийт сургуулиудын 14 нь буюу 48.3% нь дундаж гүйцэтгэлээс дээгүүр, 15 нь буюу 51.7% нь дунджаас доогуур гүйцэтгэлтэй гарсан байна.СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААР: 1. ПИСА Олон улсын судалгааны даалгавар, аргачлалыг таниулах, түгээн дэлгэрүүлэх болон		
--	--	--	--	--	---	--	--

					дээрх шалгалт, судалгааны үр дүнг танилцуулах цахим сургалтыг 2024.10.28-31-ний өдүүдэд үндэсний хэмжээнд бүсчилсэн байдлаар зохион байгуулж, аймаг, нийслэлийн боловсролын газрын мэргэжилтэн болон 4000 гаруй багш хамрагдлаа. Хавсралт: 3 файл		
11	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон багшийн ажлын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана.	Гүйцэтгэлийн үнэлгээ, хувь	Цэцэрлэг /байгууллага/-90,2 багш 90,11	Цэцэрлэг /байгууллага/-92 багш 92	БНБТГ-ын даргын 2024.01.19-ний өдрийн 3/286 дугаар албан бичгээр СӨБ-ын сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 2024 оны 04 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд зохион байгуулахаар товлож, 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээнд 1129 СӨББ, 1117 цэцэрлэгийн эрхлэгч, 847 арга зүйч, 7036 багш хамрагдсан байна. Үүнээс: СӨБ-ын багшийн гүйцэтгэлийн дундаж улсын хэмжээнд 88.62% ба I индексийн түвшинд 510 (нийт багш нарын 7.2%), II индексийн түвшинд 938 (нийт багш нарын 13.3%), III индексийн түвшинд 911	4-р сар, 5-р сар, 8-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					(нийт багш нарын 12.9%), IV индексийн түвшинд 1424 (нийт багш нарын 20.2%), V индексийн түвшинд 3253 (нийт багш нарын 46.2%) багш тус тус үнэлэгдсэн байна. Хавсралт: 1 файл		
12	Ерөнхий боловсролын сургалтын байгууллага болон багшийн ажлын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана.	Гүйцэтгэлийн үнэлгээ, хувь	Байгууллага - 74.22 Багш - 75.71	Байгууллага - 76.5 Багш - 77.5	БНБТГ-ын даргын 2024.01.19-ний өдрийн 3/286 дугаар албан бичгээр Төрийн болон хувийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 2024 оны 04 дүгээр сарын 29-өөс 5 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулахаар товлож, Улсын хэмжээнд 708 сургууль хамрагдсанаас улсын дундаж 78.62%, I индексийн түвшинд 62 сургууль (нийт сургуулийн 8.76%), II индексийн түвшинд 106 (нийт сургуулийн 14.97%), III индексийн түвшинд 118 (нийт сургуулийн 16.67%), IV индексийн түвшинд 105 (нийт сургуулийн 14.83%), V индексийн түвшинд 315 (нийт сургуулийн 44.49%) сургууль тус тус үнэлэгдсэн байна. ЕБС-ийн багшийн үнэлгээнд	4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					28743 багш хамрагдсан ба улсын дундаж 77%. Үүнээс: I индексийн түвшинд 1874 (нийт багш нарын 6.5%), II индексийн түвшинд 5481 (нийт багш нарын 19.0%), III индексийн түвшинд 4604 (нийт багш нарын 16.0%), IV индексийн түвшинд 4419 (нийт багш нарын 15.3%), V индексийн түвшинд 12365 (нийт багш нарын 43.0%) багш тус тус үнэлэгдсэн байна.		
3.2. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах							
13	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнана.	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилт хангагдсан байна.	2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтын биелэлтийг тухай бүр тайлагнаж байсан. 2.3.3.Ерөнхий боловсролын сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулж, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ. 2.3.8.“Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлнэ.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

14	МУ-ыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнана.	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	МУ-ыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тухай бүр тайлагнаж ирсэн. 2.1.2.ерөнхий боловсролын сургалтын чанарын үндэсний үнэлгээг жил бүр хийж, олон улсын үнэлгээнд хамруулна. .1.7.багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжийг суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана.	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
15	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнана.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо	2023 оны биелэлт	Холбогдох заалтын хэрэгжилт	2022_7. Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай / 2022-01-05 / ЗГ-ын тогтоол, 2024_59. Морин хуурын улсын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний тухай / 2024-02-14 / ЗГ-ын тогтоол, 2023_49. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл / 2023-12-06 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг тус тус хугацаанд нь гаргаж хэрэгжилтийг хангасан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

16	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	Холбогдох заалт	-	-	Тайлагнах боломжгүй.	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
17	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	-	Холбогдох мэдээллийг байршуулсан байна.	Батлагдсан нийтэд хамааралтай тушаал шийдвэрүүдийг холбогдох байгууллагат өгч, цахим сайтад байршуулж ажиллаж хэвшсэн.	12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг судална.	Эрхлэх асуудалд хамаарах шинээр батлагдсан хууль тогтоомжийг судлах, сан үүсгэх	2023 онд Батлагдсан хууль тогтоомжууд	Эрхлэх асуудалд хамаарах шинээр батлагдсан хууль тогтоомжийг судлан, сан үүсгэсэн байна.	2024 оноос шинээр хэрэгжих болон шинэ зохицуулалт орсон хуулиуд болох Боловсролын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Тэтгэврийн тухай хууль, Улс төрийн намын хууль, Хувь хүний орлогын албан татварын хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хуулийн шинэчилсэн найруулга, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2024 оны хувь хэмжээг өөрчлөн тогтоосон, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгуудтай тус тус танилцсан.	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 70%
2	Монгол бичгээр цахим бичвэр боловсруулж сурсан байна.	Монгол бичгээр цахим бичвэр боловсруулах гарын авлагыг ашиглан	Монгол бичгийн унших, бичих бүрэн чадвэртэй.	Монгол бичгээр цахим бичвэр боловсруулах гарын авлагыг ашиглан цахим	Монгол бичгээр цахим бичвэр боловсруулах гарын авлагыг ашиглан цахим бичвэр боловсруулах бэлтгэлийг хангаж, компьютертээ фондыг	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

		суралцах		бичвэр боловсруулж сурсан байна.	суулган бичвэр бичиж сурав " ᠰᠤᠭᠤᠯᠠᠩ ᠪᠢᠴᠢᠠᠷ ᠪᠢᠴᠢᠵᠢ ᠰᠤᠷᠠᠪ "		үнэлгээ: 100%
3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байх	2013 онд сургалтад хамрагдаж А3 сертификат авч байсан.	-	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хамрагдсан	3-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэлийн үнэлгээний бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч, Цагаан-Өвгөн Бумангэрэл /...../

Огноо: